

Эмэгтэйчүүд ба Хөгжил

А. Солонго
Монгол Улсын Их Сургууль,
Эдийн Засгийн Дээд Сургууль,
Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв,
багш

Цуврал лекц-1

Хүйсийн талаарх ойлголт, тодорхойлолтууд тэдгээрийн ач холбогдол

Удиртгал

"Хэрвээ бид эмэгтэйчүүдийг анхаарч, тэдний хэрэгцээг хангахад гол анхаарлаа төвлөрүүлж чадвал хүн амын маргаантай асуудлууд өөрөө шийдэгдэнэ."
Др. Н. Садик (НҮБ-ийн Хүн Амын сангийн Гүйцэтгэх захирал)

Өнөөдөр эмэгтэйчүүдийн аж байдал нь дээшилсэн бүх оронд хүн амын хөтөлбөр тууштай хэрэгжиж байна. НҮБ-аас 1976-1985 оныг Эмэгтэйчүүдийн 10 жил болгон зарласан явдал нь эмэгтэйчүүдийн эрх болон байдлыг судлах, шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийг оролцуулах эхлэлийг дэлхий дахинаа тавьсан билээ. Олон орны төр засгаас эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангахад үйлчлэх хууль тогтоомжуудыг батлан гаргаж, үндэсний механизмуудыг бий болж, нийгмийн бүх хүрээнд хүйсийн асуудлыг зохих ёсоор авч үзэх боломжийг хангах үндэс суурь тавигдлаа. Олон улсын байгууллагуудаас ч эмэгтэйчүүдийн байдал болон тэдний гүйцэтгэж байгаа үүргийн талаар ихээхэн анхаарах болжээ. Түүнчлэн засгийн газрын бус сектор ялангуяа эмэгтэйчүүдийн байгууллага, бүлгүүд улам бүр бэхжиж байгаа нь өөрчлөлтөд хүрэх "Хөдөлгөгч хүч" боллоо.

Хүн ам хөгжлийн төлөвлөлтийн эгзэгтэй асуудлуудын нэг нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн тэгш байдлын асуудал юм. Учир нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь нь нийгмийн харьцаа, эдийн засаг, өрх, гэр бүлийн бүтцийн үндэс болж өгдөг. Хөгжлийн талаарх аливаа төсөл, бодлого хөтөлбөрүүдийг санаачлах, хэрэгжүүлэх нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алиных нь нийгэмд гүйцэтгэх үүрэг ролийг дээшлүүлж байдаг. Нөөц бололцоо, хүчин зүйлс, үйл ажиллагаа тэдгээрт тавих хяналтын дагуу хүйсийн ялгааг судлах нь аливаа төслийн загварыг тодорхой болгох ач холбогдолтой бөгөөд судалгааны хүрээ нь маш уян хатан байх шаардлагатай. Аливаа шийдвэр тухайлбал: төрөлтийн шийдвэр нь гэр бүл төлөвлөлт, хүн ам зүйн төслийн хүрээнд шийдвэрлэгдэнэ. Ийм шийдвэр нь нийгэм эдийн засаг, улс төр, хүн ам зүйн хүчин зүйлээс хамаарна. Эдгээр нь үйл ажиллагаа, нөөц бололцоо, хяналтанд мөн л нөлөөлнө. Хүйсийн ялгааны талаархи судалгаа шинжилгээ нь дээрх үндсэн нөлөөллүүдийг хамаарах бөгөөд аливаа төслийн загварыг тодорхойлоход чухал үүрэгтэй. Иймд бид юуны өмнө хүйсийн талаархи үндсэн ойлголттой болох хэрэгтэй. Анхныхаа лекцээр энэ сэдвийг хөнхөх болно.

Хүйсийн талаархи үндсэн ойлголтууд

"Эмэгтэйчүүд хөгжилд" гэсэн ойлголт хүн төрөлхтөний түүхэнд улам бүр ач холбогдолтой болсоор байгаа учраас эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг судлах, түүний ач холбогдлыг нь улам бүр зөв илэрхийлэх үүднээс хүн ам зүйн шинжлэх ухаанд дараах үндсэн ойлголтуудыг авч үздэг. Гэхдээ улс орон

бүрийн онцлогоос шалтгаалаад эдгээр ойлголтуудыг янз бүрээр тодорхойлдгийг ямагт санаж явах нь чухал юм.

1. Хүйсийн ялгаа:

Энэ нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүргээр илэрхийлэгдэнэ. Эдгээр үүрэг роль нь цаг хугацаа улиран өнгөрөх тутам улс нийгмийн хооронд харилцан өөр хэлбэрээр өөрчлөгдөж байна.

Эрэгтэй эмэгтэй гэсэн ойлголтыг нийгэмд яаж авч үздэг вэ? гэдгийг дараах байдлаар авч үзэж болох юм.

Онцлог байдал	Хүйс	
	Эрэгтэй хүн	Эмэгтэй хүн
Физиологийн хувьд	хүчтэй, бадриун, паргил дуу хоолойтой гэх мэт ...	уян зөөлөн, гоо сайхан, булбарай, энэхрий гэх мэт ...
Эдийн засгийн хувьд	хүнд ажил (биеийн хүчний хүнд хүчир ажил) эрхэлдэг	хөнгөн ажил (хөнгөн чанарын ажлууд) эрхэлдэг
Сэтгэл зүйн хувьд	гол шийдвэр гаргадаг (гэрийн эр хүн)	туслах чанарын үүрэгтэй

Шинжлэх ухаан, техникийн хөгжлийн үр дүнд өнөөдөр физиологийн онцлог байдлийг мэс заслын аргаар өөрчилж байна. Жишээ нь: мэс заслын аргаар хүйсээ солих, гадна төрхөө, ааш араншингаа өөрчлөх гэх мэт. Эдийн засгийн хувьд зөвхөн эрчүүд л хүнд хүчир ажил хийдэг гэвэл учир дутагдалтай. Уул уурхайн, газар шорооны гэх мэт хүнд хүчир ажлыг эмэгтэй хүн ч гэсэн хийдэг. Нөгөө талаас байгууллагын нарийн бичиг, бичиг хэрэг, утас залгагч, оёдолчин зэрэг хөнгөн чанарын ажлуудыг эмэгтэйчүүдээс гадна эрэгтэйчүүд ч гэсэн сайн хийх баталгаа бий. Шийдвэр гаргах дээд түвшинд эрт дээр үеэс л эрэгтэйчүүд давамгайлж байсан гэвэл учир дутагдалтай болно. Эмэгтэйчүүд ч ийм шийдвэр гаргадаг. Жишээ нь: Улсын ерөнхийлөгч, парламентийн гишүүд, шүүх засаглалд эмэгтэйчүүд тодорхой байр суурь эзэлж байна. Тухайлбал, 1990 оны байдлаар НҮБ-ын гишүүн 159 орны зургаа нь (Исланд, Ирланд, Никарагуа, Норвеги, Филиппин, Доминикан) эмэгтэй тэргүүнтэй байсан. Тухайн үед өөрийн улс орныг амжилттай удирдан жолоолдож байсан бидний сайн мэдэх Энэтхэгийн ерөнхий сайд агсан Индра Ганди, Пакистаны ерөнхий сайд Беназир Юхто нарыг ч нэрлэж болно.

Гэвч эрэгтэй, эмэгтэй хоёрын хооронд нэг том ялгаа бий. Энэ нь эмэгтэйчүүд нөхөн үржихүйн процесст оролцож "Эх" болдог бөгөөд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн биологийн *цэвэр ялгаа* юм.

2. Хүйсээр агрегатлагдаагүй мэдээлэл:

Энэ нь судалгаа шинжилгээний үр дүнд хүйсийн ялгаатай цуглуулагдсан мэдээлэл юм. Өөрөөр хэлбэл эрэгтэй, эмэгтэй гэсэн ялгаатай хоёр бүлгийн статус, нийгэм эдийн засгийн үүрэг ролийг тус тусд нь илэрхийлсэн мэдээллүүд юм. Хүйсийн ялгаатай мэдээллийг яагаад авч үзэх шаардлагатай байдаг вэ? Энэ нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдалтай шууд холбоотой. Жишээ нь: Дэлхийн зарим улсуудын хүн амын нас баралтын түвшинг хүйсийн байдлаар авч үзье. (хүснэгт 1)

Хүснэгт 1-ээс НБТК (эм.) < НБТК (эр.) гэсэн ерөнхий чиг хандлага ажиглагдаж байна.

Эмэгтэйчүүдийн нас баралтын ерөнхий түвшинд эхийн эндэгдэл ихээхэн нөлөө үзүүлдэг. Аливаа улс орны эмэгтэйчүүдийн статус, эрүүл мэндийн системийн хөгжил, хэрэглээ байдлыг тусгадаг үзүүлэлт нь эхийн эндэгдэл юм. Ихэнх хөгжиж буй орнуудын төрөх насны эмэгтэйчүүдийн эндэгдэл нь жирэмсний ба төрөлтийн

үеийн хүндрэлээс болж байгаа бөгөөд энэ нь сүүлийн үед өсч байна. Жил бүр хагас сая орчим эмэгтэйчүүд жирэмслэлтээс болж нас барж байгаагийн 99 хувь нь хөгжиж буй орнуудад ноогдож байна.

Нас баралтын тусгай коэффициент (НБТК)
(хүйсээр, 1990 оны байдлаар)

Улсууд	НБТК (эрэгтэй хүн ам)	НБТК (эмэгтэй хүн ам)
Канад	7,9	6,5
Куба	7,6	6,0
Панама	4,6	3,5
Бразил	6,7	4,6
Вангладеш	12,3	11,6
Гонконг	5,5	4,5
Япон	7,3	6,0
Австри	10,4	11,1
Болгар	13,5	10,7
Франц	9,9	8,8

Ашигласан материал: Demographic Yearbook 1992.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагийн судалгаанаас үзэхэд жирэмслэлт ба төрөлтийн үеийн эндэгдлийн амь өрсөн байдал нь зарим хөгжиж буй орнуудад 20 тохиолдолд 1 байхад хөгжилтэй орнуудад 10000 тохиолдолд 1 байна. Эдгээр эндэгдлийн 1/5 нь хууль бус үр хөндөлтөөс болж байна. Дэлхийн улс орнуудын 90 хувьд нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалахын тулд үр хөндөлтийг зөвшөөрсөн хууль байдаг боловч үр хөндөлтийн тодорхой хувь нь эмнэлэгийн бус нөхцөлд хийгдэж, үүнээс болж нас барах эсвэл гэмтэл авах явдал гарч байна. Олон Улсын бага хурал, конвенцид дэлхийн хэмжээний уулзалт, хөтөлбөрүүдэд статистикийн мэдээ гаргахдаа ямагт хүйсээр салгаж үзэх ёстой гэж үзэж байна. Учир нь эмэгтэйчүүдийн насан туршийн хэрэгцээг хангах, тэдний олон тооны үүрэг хариуцлага, ачааллыг хуваарилах шаардлага, хөдөөгийн болон тахир дутуу эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээ, насны байдал, нийгэм эдийн засаг, соёлын ялгаатай уялдан эмэгтэйчүүдийн хэрэгцээ шаардлага олон янз байх зэргийг харгалзах үүднээс хүйсээр ялгаварласан мэдээллийг шаардаж байна. Тухайлбал, хүйсийн ялгавартай нас баралтыг тооцё гэвэл түүвэр судалгааг илүү нарийн зөв, тодорхой гаргах хэрэгтэй.

3. Хүйсийн харанхуй (харалган) байдал

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлах чадваргүй байдлыг хэлнэ. Энэ байдлын уршгийг харгалзан үзээгүй тохиолдолд харилцан ялгаатай тусах ёстой аливаа бодлого, хөтөлбөр төслийг хэрэгжүүлэх боломжгүй байдаг. Тодруулбал шийдвэр гаргах түвшинд амжилт олохгүй. Үүнийг боловсрол буюу бичиг үсэг мэдэлтийн түвшингээр жишээ авч тайлбарлая.

Өнөөдөр дэлхий дээр 960 сая хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагийн 2/3 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байна. Монголд бичиг үсэг мэдэлтийн түвшин хүйсийн хувьд ялгаа бага байдаг. Харин хөгжиж буй нэлээд олон оронд энэ үзүүлэлт асар их зөрүүтэй байна. Жишээ нь: Энэтхэгт 1991 оны байдлаар бичиг үсэг мэдэлтийн түвшин эрэгтэйчүүдэд 64 хувь, эмэгтэйчүүдэд 32 хувь байсан бөгөөд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ бичиг үсэг мэдэлтийн түвшингээрээ 2 дахин бага байна. Өнөөдөр дэлхий дээр 130 сая орчим хүүхэд боловсролгүй байгаагийн 91 сая буюу 70 хувь нь эмэгтэй хүүхдүүд байна. Эмэгтэйчүүд, охидын бичиг үсэг мэдэлтийн түвшин

яагаад муу байна вэ? гэдгийг авч үзье. Хүмүүсийн сэтгэхүйд эмэгтэй хүн, охидуудыг залуу насандаа гэрлэж, хүүхэд төрүүлэх, тэднийгээ өсгөж, хүмүүжүүлэх, тэжээх, гэр орны ажил хийх зарим тохиолдолд охидыг зөвхөн гэрийн эзэгтэй, хүүхдийн эх байх ёстой гэж үздэгээс боловсролыг илүүдсэн зүйл гэж ойлгодог байна. Ийм учраас тэдэнд сургуульд сурах боломж олддоггүй байна. Түүнчлэн зарим улс оронд их, дээд, дунд сургуулиудад хүйсийн ялгаа их байгаагаас охидын сурч боловсрох идэвхийг дэмждэггүй, заримдаа тэдэнд цаашид сурахыг зөвшөөрдөггүй тохиолдол ч байсаар байна.

Боловсролтой, ажил хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд өөрсдийн *чухал эрх* болох эрүүл мэндийн эрх, нөхөн үржихүйн сонголтын эрхээ шаардаж эдлэх чадвартай байдаг. Түүнчлэн боловсролтой эмэгтэйчүүд нь бичиг үсэг үл мэддэг эмэгтэйчүүдийг бодвол гэр бүлийн амьдралыг хожуу эхэлж, цөөн хүүхэдтэй байх хандлагатай байдаг бөгөөд нийгэмд өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр, улс төрийн эрх чөлөө, ардчилалыг дэмжигчид байдаг төдийгүй хувийн болон нийгмийн амьдралдаа зөв сонголт хийж, амьдралын аливаа асуудал шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Зах зээлийн эдийн засгийн үед санхүүгийн хэрэгцээ их байх нь гарцаагүй. Гэтэл эрэгтэйчүүд боловсрол эзэмших нь илүү ашигтай гэх үзэл байсаар байна. Энэхүү хэрэгцээг боловсрол гэж үзээд 5 ам бүлтэй өрхөөр жишээ болгон авч үзье. Хязгаарлагдмал нөөцөө эдгээр 5-н хүндээ яаж хуваах вэ? гэдэг асуудал гарч ирнэ. Хамгийн их орлого оруулж буй гишүүн буюу өрхийн тэргүүлэгчид санхүүгийн анхны хуваарилалт болох санхүүгийн эх үүсвэр очно. Дараа нь тухайн өрхийн өв залгамжлагч болох хөвгүүдэд ногдоно.

4. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх – өрхийн аж ахуй :

Салалт, тусгаарлалт, шилжих хөдөлгөөн, гэрлээгүй, бэлэвсрэлт зэргийн улмаас тухайн хугацаанд насанд хүрсэн эрэгтэй хүнгүй өрх, өрхийн аж ахуй эсвэл хэдийгээр насанд хүрсэн эрэгтэй хүнтэй боловч тэр нь өрхийн орлогод хувь нэмэр оруулдаггүй өөрөөр хэлбэл, архаг хууч өвчтэй, архичин, мансууруулах бодис хэрэглэдэг зэргээс болж ямар ч хөдөлмөр эрхлэх, өрх толгойлох чадваргүй өрх, өрхийн аж ахуйг *эмэгтэй тэргүүлэгчтэй өрх, өрхийн аж ахуй* гэнэ.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо дэлхийн хэмжээнд нэмэгдсээр байгаа нь нэлээд анхаарал татсан асуудал болж байна. Африк, хөгжингүй орнууд, Латин Америк, Карибын тэнгисийн орнуудын нийт өрхийн 20 хувь орчмыг өрх толгойлсон эмэгтэй эзэлж байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүд Ази Номхон далайн орнуудад нэмэгдэх хандлагатай байна. Хөгжингүй бүс нутгуудад өрх толгойлсон эмэгтэй ганцаараа амьдарч байхад буурай хөгжилтэй олонхи орнуудад (гэр бүлийн хүнгүй) нөхөргүй хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд байна. Түүнчлэн эмэгтэй тэргүүлэгчтэй өрх, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийг бодвол илүү ядуу амьдарч байна. Олон гишүүнтэй өрхийн хувьд тэжээгч нь нэг л хүн байна. Буурай хөгжилтэй орнуудад 2 болон түүнээс дээш гишүүнтэй эмэгтэй тэргүүлэгчтэй өрх нэлээд хувийг эзэлж байна. Өндөр настай хүмүүсийн гэр бүлийн ихээхэн хувийг эмэгтэйчүүд толгойлж байна. Ази Номхон Далайн орнуудад 1 гишүүнтэй өрх нийт өрхийн 8,2 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн 45 хувь нь эмэгтэйчүүд, 55 хувь нь эрэгтэйчүүд эзэлж байна. Африк, Латин Америк, Карибын орнуудад эмэгтэй өрхийн тэргүүлэгчийн нас залуужих хандлагатай, хөгжилтэй орнуудын хувьд хөгшрөх хандлагатай байна. Түүнчлэн Африк, Латин Америк, Карибын бүс нутгуудад нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд өрх толгойлох нь түгээмэл байна. Африк, хөгжингүй орнууд, Ази Номхон далайн бүс нутагт өрх толгойлсон эмэгтэй нь бараг тал хувь нь бэлэвсэрсэн байхад Латин Америк 28 хувь нь бэлэвсэн, 36 хувь нь ганц бие гоонь хүмүүс байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн дотор салсан эмэгтэйчүүдийн хувийн жин Ази Номхон далайн орнуудад бусдаас онцгой

бага 6 хувь байхад Латин Америк Карибын сав газар 13 хувь Африкт 15 хувь өндөр хөгжилтэй орнуудад 16 хувь байна.

5. Хүйсийн талаархи судалгаа :

Эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах үйлс нь тоо мэдээлэлгүйгээр санахын аргагүй юм. Тоо мэдээлэл нь эмэгтэйчүүдийн амьдрал хэрхэн өөрчлөгдөж байгаа аль эсвэл өөрчлөгдөхгүй байгааг бүхэлд нь бүсчилсэн байдлаар, улс орны хэмжээнд гэх мэтээр авч үздэг. Тэгш эрх, Хөгжил, Энх тайван уриан дор цуглаж дэлхийн 158 орон санал нэгдэн дэлхийн эмэгтэйчүүдийн 10 жилийг (1976–1986) зарласан Найробын хуралдаанаас эмэгтэйчүүдийн статус, эрх тэгш байдлыг дээшлүүлэхэд тэдгээрийн талаархи статистикийн мэдээллийг бий болгох, сайжруулах явдал онцгой чухал юм гэдгийг санал нэгтэй зөвшилцжээ.

Эмэгтэйчүүдийн байдлыг шударга, үнэн зөв тодорхойлохын тулд тэдгээрийн байдлыг юуны өмнө эрэгтэйчүүдийнхтэй зэрэгцүүлэх шаардлагатай. Тухайлбал, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалин хөлс, орлогын ялгаа нь тухайн гэр бүлд, тухайн нийгэмд эдийн засгийн эрх үүрэг доогуур, боловсрол эзэмших, нийгмийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцох оролцоо доогуур байгааг илэрхийлдэг. Хэдийгээр боловсрол, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн оролцоо ижил хэдий ч цалин хөлс нь ялгаатай тохиолдолд эмэгтэйчүүдийн эрх тэгш бус байдлыг илэрхийлдэг. Гэтэл энэ байдлыг илэрхийлэхүйц статистикийн тогтолцоо байхгүй нөхцөлд эмэгтэйчүүдийн байдлыг тодорхойлох талаар ярихад хэцүү болно.

Хүйсийн талаархи судалгаа гэдэг нь эмэгтэйчүүдийн үүрэг ролийг аль болох системтэйгээр баримтжуулах, ойлгох гэсэн үг юм. Энд гол түлхүүр болох дараах үндсэн асуудлууд гарч ирдэг.

а) Үйлдвэрлэл, нөхөн үржихүйд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үүрэг, хөдөлмөр хуваарилалт

б) Нөөц баялаг, ашиг орлогын хүртээмж, тэдгээрт тавих хяналт

в) Нийгэм эдийн засаг, байгаль орчны нөлөөлөл зэрэг болно. Эдгээрийн талаар бид дараагийн лекцэндээ дэлгэрүүлж үзэх болно.

6. Хүйсийн мэдрэмжтэй төлөвлөлт буюу эмзэг асуудлын төлөвлөлт:

Эмэгтэйчүүд тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг хөндсөн бодлого төлөвлөлтийг хүйсийн мэдрэмжтэй төлөвлөлт буюу эмзэг асуудлын төлөвлөлт гэнэ.

Өнөөдөр дэлхий дахинд 1 тэрбум гаруй хүн голдуу хөгжиж байгаа орнуудад ядуурлын тэсвэрлэшгүй нөхцөлд аж төрж байгаагийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна. Ядууралд бүтцийн шинжтэй янз бүрийн шалтгаан бий. Ядуурал нь олон талтай, хэцүү асуудал бөгөөд түүний уг язгуур нь үндэсний болон олон улсын шинжтэй байдаг. Эдийн засгийн тогтворгүй байдал уур амьсгалыг бүхэлд нь эдийн засгийг шинэчлэн байгуулах явц түүнээс гадна зарим оронд буурашгүй, зохицуулашгүй гадаад өрийн асуудал, тэрчлэн элдэв янзын мөргөлдөөн, хүн амын нүүдэл, шилжилт, хүрээлэн байгаа байгаль орчны доройтол зэрэг нь өөрийн орны хүн амын үндсэн хэрэгцээг хангах гэсэн Засгийн Газрын боломжийг эвдэж байна. Энэ нь хүн амын ядуурлын түвшинд хүчтэй нөлөөлж байна.

Эмэгтэйчүүдийн дотор ядуурал ихсэн, түүний цар хүрээ нь бүсээс бүсэд янз бүр болон тэлсээр байгаа явдал нь туйлын ноцтой бөгөөд эмэгтэйчүүдийн доторхи ядуурлыг дэвэргэж байгаа айхавтар хүчин зүйл нь эдийн засгийн эрх мэдэл эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд тэгш бусаар хувиарлагдаж буй явдал юм. Ядуурлыг устган тогтвортой хөгжилд хүрэхийн тулд макро эдийн засгийн болон нийгмийн бодлогыг томьёолох, тэрчлэн ядуурлыг бууруулах стратегид эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд бүх талаар тэгш эрхтэй оролцох ёстой. Зөвхөн ядуурлыг бууруулах хөтөлбөрөөр ядуурлыг арилгаж чадахгүй, ядуурлыг арилгах асуудал нь

бүх эмэгтэйчүүдийг нөөц баялаг, боломж, төрийн албанд хүрэх болоцоогоор хангах зорилгоор тэднийг эдийн засгийн бүтцэд ардчилсан ёсоор оролцохыг шаардаж байгаа юм.

Ядуурал янз бүрийн хэлбэрээр илэрнэ. Тухайлбал, тогтвортой амь зуулгыг хангахуйц орлого ба үйлдвэрлэлийн нөөц баялаггүй байх, өмсөх идэх юм хүрэлцэхгүй байх, эрүүл мэндээр сул дорой болох, боловсрол олох болон бусад үндсэн үйлчилгээ хийлгэх боломж хязгаарлагдмал буюу огт үгүй байх, өвчлөх болон үхэх явдал их байх, орон байргүй буюу орон байрны нөхцөл муу байх, хүрээлэн буй орчин эрүүл бус байх, нийгмийн амьдралд оролцохоос ялгаварлан гадуурхах буюу шахан гаргах зэрэг байдлаар илэрч болно. Тэрчлэн иргэний, нийгмийн, соёлын амьдралд шийдвэр гаргахад хангалтгүй оролцуулах явдал ядууралд хамаарна. Өнгөрсөн 10 жилд ядуу амьдарч буй эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдтэй харьцуулахад ялангуяа хөгжиж буй орнуудад тэнцвэргүйгээр өссөн байна. Сүүлийн жилүүдэд ядуурал эмэгтэйчүүдийн хүрээнд шилжиж байгаа нь шилжилтийн эдийн засагтай улс орнуудын хувьд улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийн түр үр дүн буюу чухал эмзэг асуудал болж байна.

Эдийн засгийн аливаа задлан шинжилгээ болон төлөвлөлтөд хүйсийн аспектиг зохих ёсоор харгалзан үзэж чадахгүй байгаа болон ядуурлын бүтцийн шалтгааныг олж арилгаж чадахгүй байгаа зэрэг нь нэмэлт хүчин зүйл болж байна. Эмэгтэйчүүдийн доторхи ядуурал нь эдийн засгийн нөхцөл боломж болон бие даасан байдалгүй, зээл, газар эзэмшил, өв залгамжлалыг оролцуулаад эдийн засгийн нөөц баялагт хүрэх боломж байхгүй, түүнчлэн боловсрол эзэмших, бусад туслах үйлчилгээ хийлгэх арга байхгүй болон шийдвэр гаргах явцад маш өчүүхэн төдий оролцох боломж зэрэгтэй шууд холбоотой. Ядуурал нь бэлгийн харьцааны дарамт учруулж болохуйц нөхцөл байдал руу эмэгтэйчүүдийг түлхэж байдаг байна.

7. Эмэгтэйчүүдийн хөгжилд оруулах хувь нэмэр буюу өөрсдөө өөрсдийнхөө төлөвлөгөөг боловсруулах нь:

Макро хөгжлийн асуудалд тухайлбал, хүн ам, байгаль орчин, ядуурал, хүнсний хомсдол, эрчим хүч, хотжилтод оруулах эмэгтэйчүүдийн боломж хувь нэмэрийг уялдуулж өгснөөр хөгжилд эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцох бололцоо нөхцөлийг сайжруулах асуудлыг хэлнэ.

8. Эмэгтэйчүүдийн тусгай төслүүд:

Эмэгтэйчүүдийн тусгай төслүүд гэдэг нь эмэгтэйчүүдийн эрх ашгийн талаар тусгайлан анхаарч хэрэгжүүлдэг төслүүдийг хэлнэ. Эдгээр төслүүд нь эмэгтэйчүүдийг тэдний эрх ашгийг хөндсөн аливаа төслийн загвар боловсруулах, тэдгээрийг шийдвэр гаргахад оролцуулахад заримдаа чиглэсэн байдаг.

9. Үндэсний механизм:

Үндэсний механизм гэдэг нь тухайн орны засгийн газраас дэмжлэг хүлээсэн эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, дэмжих алба юм. Үүнд : Улсын эмэгтэйчүүдийн хороо, холбоо мөн засгийн газрын бус байгууллагууд байж болно. Жишээ болгож Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Либераль эмэгтэйчүүдийн оюуны сан зэргийг нэрлэж болно.

10. Эмэгтэйчүүдийн онцгой постууд:

Эмэгтэйчүүдийн болон хөгжлийн программуудыг хариуцсан байгууллагуудад ажилладаг удирдах хувь хүмүүсийг хэлнэ. Тухайлбал, засгийн газрын болон

засгийн газрын бус байгууллагуудад онцгой албан тушаал эрхэлж байгаа хүмүүс юм.

11. Эмэгтэйчүүд хөгжилд:

Эмэгтэйчүүд хөгжилд гэсэн ойлголт нь эмэгтэйчүүдийн үүрэг рольд ач холбогдол өгөх, аливаа нийгэм, хөгжлийн процесст эмэгтэйчүүдийн тэгш бус эрх ашигтай байгаа байдлыг баримтжуулж мэдээллийг гол болгодог. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхийн талаарх судалгаа, шинжилгээ нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нийгмийн идэвх, үүрэг хариуцлагыг мөн түүнчлэн бодлого хөтөлбөр төслийн үйл ажиллагаа эрэгтэйчүүд эмэгтэйчүүдэд хэрхэн төсөөтэй буюу ялгаатай нөлөөлж байна вэ? гэдгийг авч үздэг.

7-11 тодорхойлолтуудын талаар дараагийн лекцэнд жишээгээр дэлгэрүүлж үзэх болно.

12. Эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн үүргүүд:

Энэ нь үйлдвэрлэл буюу эдийн засгийн үйл ажиллагаа байнгын нөхөн үржихүй буюу хүний нөөцийг бий болгох процессын хоорондын ялгааг илэрхийлдэг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа гэдэгт өрх, өрхийн аж ахуйн нийгэмд оруулах эдийн засгийн хувь нэмрийг тодруулбал, газар тариалан, мал аж ахуй, гар урлал, зах зээл эрхлэлт гэх мэт үйл ажиллагааг оруулна.

Зарим улс оронд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөлсийг доогуур үнэлдгээрээ эдийн засгийн бодлого нь доголдолтой байдаг. Жилд дундажаар эмэгтэйчүүдийн үнэлэгдээгүй хөлсийг тооцоход 4 триллион ам.долларт хүрээд байна. Гэтэл эмэгтэйчүүд үндсэндээ өрх гэрийнхээ үндсэн хэрэгцээний 40-100 хувийг хангадаг гэсэн тооцоо гарчээ. Түүнчлэн зарим оронд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалин хөлс ялгаатай байдаг. Энэ нь эрэгтэйчүүдийн ажлын цаг нь харьцангуй урт, эмэгтэйчүүдийг бодвол илүү их хүнд хүчир ажил хийдэгтэй ихэвчлэн холбоотой гэж үздэг. Хүйсээр ялгавартай цалингийн коэффициент нь ихэвчлэн төр засгаас авч явуулж буй бодлого болон хувь хүмүүсийн өөрсдийнх нь практик үйл ажиллагаанаас ихэвчлэн шалтгаалдаг. Тухайлбал, Дэлхийн хөдөлмөрийн статистикийн байгууллагаас жил бүр гаргадаг мэдээллийн номонд 1972-1984 оны хооронд 14 хөгжиж буй орнуудад эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн цалин хөлсний харьцааг харуулсан тооцоо хийхэд эмэгтэйчүүдийн цалингийн коэффициент 75-92 хооронд хэлбэлзэж байжээ. Энэ үзүүлэлт Өмнөд Солонгост эмэгтэйчүүдийн цалингийн коэффициент нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 46 хувь, Сальвадор 83 хувь, Бирмад 90 хувь байсан байна. Цалин хөлсний энэхүү ялгаанд маш олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд юуны түрүүнд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийг бодвол дадлага, мэргэжлийн ур чадвар бага шаардагддаг, хөдөлмөрийн бүтээмж маш бага мэргэжлийн салбарт (хөнгөн үйлдвэр, худалдаа, үйлчилгээний) ажилладаг. Гэрлэх хүүхдээ төрүүлэх зэргээс шалтгаалан хөдөлмөрийн завсарлага их, ажиллах хугацаат жил нь харьцангуй богино, өдрийн ажлын цаг бага, мэргэжил боловсролын түвшин харьцангуй доогуур зэргээс шалтгаалдаг байна.

Өрхийн аж ахуйн бараг бүх төрөл эмэгтэйчүүдийн орлогоос улам бүр хамаардаг боллоо. Зарим бүс нутагт ялангуяа албан бус секторт эмэгтэйчүүдийн арилжаа-үйлдвэрлэлийн идэвхжил, бие даасан үйл ажиллагаа өргөжиж байгаа нь ажиглагдаж байна. Олон оронд эмэгтэйчүүд түр болон тохиолдлын ажил эрхлэх бүрэн бус ажлын өдрөөр хавсран ажиллах, гэрээгээр болон айлын гэрт ажиллах зэрэг стандартын бус ихэнх ажлыг гүйцэтгэдэг *ажиллах хүч* болж байгаа төдийгүй шилжин суурьшигч эмэгтэйчүүдийн доторхи ажилтгүйдлийн түвшин шилжин суурьшигч болон түр суурьшигч эрэгтэй ажилтнуудтай харьцуулахад өндөр байдаг байна.

13. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн үүргүүд:

Нөхөн үржихүйн буюу хүний нөөцийг бий болгох процесс нь хүнийг нөхөн үржүүлэх, өрх өрхийн аж ахуйн нийгмийн халамжийг бий болгох, тухайлбал: түлш татах, ус авах хоол унд бэлтгэх, хүүхэд асрах, боловсрол эрүүл мэндийн халамж, гэр орны ажил зэргийг хэлнэ. Үүнийг ихэвчлэн эдийн засгийн бус үйл ажиллагаа гэж үздэг. Голчлон орлого оруулдаггүй учир үндэсний тооцооноос хасагдсан байгааг анхаарах хэрэгтэй.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд нь хүмүүсийн хангалуун, аюулгүй бэлгийн харьцаа дахин үржих бололцоо, хүссэн цагтаа хүүхэдтэй болохоо чөлөөтэйгээр шийдвэрлэх утга санааг агуулж байдаг.

Дэлхий хэмжээнд 1960-оноос хойш гэр бүл төлөвлөлт асар үр дүнтэй хэрэгжиж байна. Тухайлбал, хөгжиж буй орнуудад гэр бүл төлөвлөлтийн түгээмэл аргуудыг олон сая хосууд (46-460 сая) хэрэглэх болж тэр үеийг одоотой харьцуулбал тэдгээрийн хүн амд эзэлж байсан хувь 5 дахин өссөн явдал юм. Гэр бүл төлөвлөлтийг нэвтрүүлснээр 1950 -аад оны үед хөгжиж буй орнуудад 6-7 хүүхэдтэй байсан бол 1994 оны байдлаар 3-4 болж төрөлтийн коэффициент буурлаа. Гэсэн хэдий ч 350 сая орчим хосууд гэр бүл төлөвлөлт болон орчин үеийн жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл үйлчилгээг хүртэж чадахгүй байна. 1994 оны статистикийн мэдээнээс үзвэл 120 сая орчим эмэгтэйчүүд орчин үеийн гэр бүл төлөвлөлтийн аргыг хэрэглэдэггүй байна. Гэрийн ажил болон хүүхдээ хүмүүжүүлэх ажил зэрэг нь эмэгтэйчүүдэд нэлээд хүндрэлтэй байдаг. Тэгвэл ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн хувьд хүүхдээ хүмүүжүүлэх, гэрийн ажил болон өөрийн цалинтай ажлын шаардлагыг нэгтгэх, хослуулах нь бүр ч их хүндрэлтэй болох нь тодорхой. Учир нь өдөр бүр гэрийн ажлаас гадна цалинтай ажилдаа урт хугацааны цагийг зарцуулдаг. Мөн түүнчлэн өөрийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, үр бүтээлтэй ажиллах, байр сууриа нэмэгдүүлэхийн тулд уг ажилд зайлшгүй зарцуулах цагийг ихэсгэх хэрэгтэй болдог. Тиймээс эмэгтэйчүүд гэртээ байх болон хүүхдээ гардан өсгөх, хүмүүжүүлэх цагаа багасгадаг. Хөгжингүй орнуудад хүүхдээ хүмүүжүүлэх ажлыг ихэвчлэн цэцэрлэг, гэрийн ажилчин (хүмүүжүүлэгч) авч туслуулдаг явдал их дэлгэрч байна. Энэ бүх үйл явц нь ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийг өөрийн төрөлтөндөө хязгаар тавих нөхцлийг бүрдүүлдэг. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт нь эхнэр нөхрийн харилцааг өөрчилдөг. Эмэгтэйчүүд ажил эрхэлж байвал өөрийн гэр бүлийн холбооноос өөрөөр хэлбэл өөрийн нөхрөөс ямар нэгэн байдлаар хараат бус байдаг бөгөөд төрөлтийн шийдэлдээ илүү их хяналт тавих боломжтой болдог. Боловсролын өсөлт, эмэгтэйчүүдийн хөдөлмөр оролцооны өсөлт нь гэрийн ажлыг эхнэр нөхрийн хооронд хувааж хийх зайлшгүй шаардлагыг бий болгодог. Гэвч гэр бүлд эмэгтэйчүүд нь гэрийн ажлын ихэнх хувийг хийсэн хэвээр байх бөгөөд дээрхи өөрчлөлт нь эрэгтэйчүүдийг өөрсдийг нь цөөхөн хүүхэдтэй байх хүсэл эрмэлзэл, шаардлагыг бий болгодог. Зарим улс орнуудын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гэрийн ажилд зарцуулдаг цагийг доорхи хүснэгтээс харъя.

		7 хоногт							
		Хоол бэлтгэх		Хүүхэд асрах		Дэлгүүр		бусад	
	он	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Австрали	1987	76	24	78	22	60	40	53	47
Финланд	1979	82	18	77	23	57	48	54	46
Перу	-	94	6	90	10	69	31	86	14
Непал	1979	88	12	81	19	41	59	76	24

Ашигласан материал

" Хүн амын асуудал " НҮБ-ийн Хүн амын сан 1993 он

" Хүн ам ба хөгжил дэвшил " НҮБ-ийн Хүн амын сан 1994 он

" A women and Development quarterly " International women's tribune centre 1994

" Demographic Yearbook " 1992

" Incorporating Women into Population and Development "

НҮБ-ийн Хүн амын сан

" The World's Women " Статистикийн эмхтгэл 1991